

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭРДЭМ ЗҮЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ БИЧИГЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

/Сургуулийн өмнөх боловсролын багш нарын жишээн дээр/

Ц.Жигмэд, дэд профессор, Т.Батболд, магистр, МУБИС

Abstract: To be a teacher who normalized international standard and executed modern technology advancements and innovation developing. We manage training based on research. So that we discuss about “teacher-researcher”. Many teachers are succeed in that field.

Issues of research works of preschool education is focused “Integrated approach on early childhood development”, “Content and methodology of preschool education” development approaches of preschool education teachers” and “research of development and formation of learners”. Preschool education teachers and scientists should cooperate and solve the issues. It is provided practical contribution to research studies of teachers.

In this paper we analyzed base level of young teachers of School of Preschool studies specially their academic writings, and inner logical interactions. For the purpose of identify vital questions we studied some studies writings and chosen reasons of dissertations and their purposes goals, object matters, subjects, conclusion drafting and methods of the researches, movities, hypothesis and formulized importance of theory and practical.

In the study we have analyzed academic writings 77 teachers who are 20-30 years old. We used integration method and 11 criterions and concluded. We considered that supporting young teachers’ researches and dissertations is importance of developing their proffessions.

Түлхүүр үг: Сургуулийн өмнөх боловсрол, боловсролын байгууллага, судалгааны ажил, тулгамдсан асуудал, дотоод логик холбоо хамаарал

Удиртгал

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын судалгааны ажлын бичвэрт эрдэм зүйн хэрэглэгдэхүүн (научный аппарат)-ий дотоод логик холбоо хамаарлыг хэрхэн гаргасныг судлах зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ. Багш нар ажиллах явцдаа бие даасан судалгааг хийдэг бөгөөд тэдний судалгааны ажлын бичвэр ялангуяа удиртгал хэсгийн дотоод логик холбоо хамаарлыг зөв бичих асуудалд дутагдал байгаа нь ажиглалтаас харагддаг. Иймд түүнийг судлан тогтоох хэрэгцээ шаардлага нь багш нарын судалгааны ажилд тодорхой дэмжлэг үзүүлэх үндэслэл болох юм. Бид сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа 77 багшийн судалгааны ажлын бичвэр, баримт материалд дүн шинжилгээ хийх аргыг ашиглаж судалгаа хийн боловсруулж, үр дүнг хүснэгт, диаграммаар илэрхийллээ.

Үндсэн хэсэг

Орчин үеийн сургуулийн өмнөх боловсролын багш нь сургалт, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, судалгаа шинжилгээний ажил хийх мэдлэг, чадвар эзэмшсэн байх шаардлагатай байна.


Шинжлэх ухааны судалгаа нь тогтсон тодорхой дүрмээр явагддаггүй бүтээлч, танин мэдэхүйн үйл ажиллагааны хамгийн хөгжингүй хэлбэр тул судалгааны ажлын сэдэв сонгохоос эхлээд судалгааны ажлын онолын үндэслэл боловсруулах, практик судалгаагаар цуглуулсан баримтыг задлан шинжлэх, судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх зэрэг бүх үйлдлүүд алгоритмын дагуу бус, эрэл хайлт хийсэн шинжтэй байдаг (Авдай, ба бус, 2013, х.52). Багш нарын судалгааны ажлын талаар судлаачид олон талаас нь судалсан байдаг бөгөөд бидний судалгаа сургуулийн өмнөх боловсролын багш нар судалгааны ажлын бичвэрийн “научный аппарат”-ыг хэрхэн бичиж байгааг илрүүлэхэд чиглэгдсэн юм. Энэхүү судалгаанаас судалгааны зорилго сэдэвтэй уялдаагүй (48%), зорилгоо сэдэв сонгосон үндэслэлтэй уялдуулж чадаагүй (32.4%), судалгааны арга, сургалтын аргыг хольсон (29.5%) зэрэг дутагдал гарсан нь тэд судалгааны ажлын үр дүнгээ бичих арга барил, туршлага дутмаг байгаа гэсэн бидний таамаглалыг баталж байна.

Судалгааны үр дүн

Энэхүү судалгаанд өмнө нь багш бэлтгэх сургуульд суралцаж, төрөл бүрийн багшийн мэргэжил эзэмшсэн, бакалавр зэрэгтэй, сургуулийн өмнөх боловсролын сургуулиар


хөрвөн суралцаж, “Сургуулийн өмнөх насны хүүхдийн багш” мэргэжлийг эзэмшсэн, одоо сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш нар хамрагдсан болно.

Зураг 1
Багш нарын боловсролын байдал




Судалгаанаас авч үзвэл дотоод, гадаадын 23 сургууль төгссөн багш нар судалгаанд хамрагдсанаас МУБИС-ийн БС-ийн Архангайн салбар сургууль төгссөн нь 24.6 %, МУБИС төгссөн нь 19.4 % бусад 21 сургууль төгссөн нь 56 % эзэлж байна.

Зураг 2
Багш нарын өмнө нь эзэмшсэн мэргэжил



Дээрх диаграммаас харахад судалгаанд хамрагдсан сургуулийн өмнөх боловсролын багш нар өмнө нь 18 төрлийн мэргэжлийг бакалаврын түвшинд эзэмшсэн байна. Эдгээрээс өндөр хувьтай нь монгол хэлний багш 23.3 %, бага ангийн багш 14.2 % байна.

Зураг 3
Багш нарын харьяалал




Судалгаанд 16 аймагт ажиллаж байгаа багш нар хамрагдсан бөгөөд үүнээс Улаанбаатар хотын багш нар (24.6%), Баянхонгорын багш нар (22%) -ийг эзэлж байна.

насны, 9% -ийг 36-40 насны, 3% -ийг 41-ээс дээш насны багш нар эзэлж байна.


Багш нарын судалгааны чиглэлийг судалж үзэхэд 86% нь бага насны хүүхдийн хөгжлийн асуудлыг, 61% нь оюун ухааны хөгжлийн талаарх судалгааны сэдвийг судалсан байна.

Зураг 4
Багш нарын насны байдал



Судалгаанд оролцогчдын 22% -ийг 20-25 насны, 58% -ийг 26-30 насны, 8% -ийг 31-35

Зураг 5
Судалгааны сэдэв сонгосон байдал



| | | | |
|--------------------|---------------------|---------------------|-------|
| Оюун ухааны хөгжил | Нийгэмшихийн хөгжил | Бие бялдарын хөгжил | Бусад |
| 47 | 10 | 9 | 11 |

Хүснэгт 1
Оюун ухааны хөгжил

| № | Оюун ухааны хөгжил | | | | | | | | | | |
|---|--------------------|-------|----|------|-------------|-----------|--|----------------|------------------|---------------|----------|
| 1 | Анхаарал | Айдас | Ой | Зори | Темперамент | Зан төлөв | Сэтгэл зүйн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдал | Зохион бодохуй | Сэтгэхүйн хөгжил | МЭТ хөгжүүлэх | Хэл яриа |
| 2 | 1 | 3 | 2 | 1 | 5 | 3 | 2 | 1 | 9 | 7 | 13 |

Дээрх хүснэгтээс харахад багш нар хүүхдийн хэл ярианы хөгжлийн түвшин тогтоох, хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх асуудлыг түлхүү судалсан байна.

Хүснэгт 2
Нийгэмшихүйн хөгжил


| Нийгэмшихүйн хөгжил | | | | |
|-------------------------|------------------------|----------|-------------------------------|------------------------|
| Цэцэрлэгт дасан зохицох | Хүүхдийн үйл ажиллагаа | Харицгаа | Хүүхдийн тоглох үйл ажиллагаа | Орчиндоо дасан зохицох |
| 1 | 1 | 3 | 4 | 1 |

Хүснэгт 4
Сэдэв сонгосон үндэслэл

| Сэдэв сонгосон үндэслэл | Маш сайн | Сайн | Дунд | Муу | Бичээгүй |
|--|-----------|-----------|-----------|------------|------------|
| Сэдвийн чухлыг гадаад эх сурвалж ашиглан тодотгосон байдал | 4 | 8 | 4 | 4 | 57 |
| Сэдвийн чухлыг дотоод эх сурвалж ашиглан тодотгосон байдал | 4 | 12 | 28 | 12 | 21 |
| Тухайн сэдвийн судлах шаардлагаа тодорхой баримтад түшиглэн гаргасан | 4 | | | 4 | 69 |
| Юуны тулд энэ сэдвийг сонгосноо оновчтой тодорхойлсон байдал | | 12 | 20 | 45 | |
| Сэдэв сонгосон үндэслэлээ судалгааны сэдэвтэй холбосон байдал | | 24 | 11 | 42 | |
| Нийт | 12 | 56 | 63 | 107 | 147 |

Судалгааны дүнгээс харахад сэдэв сонгосон үндэслэлийг бичсэн боловч ихэнх нь хангалтгүй эсвэл огт бичээгүй байна. Энэ нь сэдэв сонгосон үндэслэл бичих тал дээр дэмжлэг туслалцаа хэрэгтэйг харуулж байна.

Зураг 6
Зорилго тодорхойлсон байдал



Судалгаанаас харахад: -Судалгаанд оролцогчдын 63% зорилгоо нэг чиглэлийн асуудал шийдвэрлэхээр оновчтой томьёолсон бол 36.6% нь 2-3 чиглэлийн асуудал шийдвэрлэхээр томьёолжээ. Хоёроос гурван

Хүснэгт 3
Бие бялдрын хөгжил

| Бие бялдрын хөгжил | | | | |
|--------------------|------------------------|----------------|-------------------|---------------|
| ББ-өсөлт хөгжил | Хүчний чанар хөгжүүлэх | Авхаалж самбаа | Хөдөлгөөний эвсэл | Биеийн галбир |
| 2 | 1 | 2 | 2 | 2 |


Дээрхээс харахад багш нар хүүхдийн нийгэмшихүй болон бие бялдрын хөгжлийг судлахдаа дараах таван чиглэлээр судалсан байна.

чиглэлийн асуудал шийдвэрлэхээр томьёолох нь цаашид судалгаа хийж, үр дүнг тооцоход хүндрэл үүсгэдэг байна.


-Судалгааны зорилгоо сэдэвтэй уялдаагүй томьёолсон 48 %, сэдэв сонгосон үндэслэлтэй уялдаагүй томьёолсон 32.4 % -ийг эзэлж байна.

Зураг 7

Зорилт дэвшүүлсэн байдал



Судалгааны зорилтыг онолын судалгаа хийхэд чиглүүлж 58.6 %, практик судалгаа хийхэд чиглүүлж 23.3 %, зорилтыг судалгааны шалгууртай холбон 51.9 %, зорилтыг судалгааны шийдвэрлэх асуудалтай холбон 10.3 % нь зөв тодорхойлсон ба зорилт нь зорилгоо биелүүлэхэд чиглэгдэж чадсан 19.4 %, зорилтоо дутуу томьёолсон 41.5 % байна. Эндээс үзэхэд судалгаанд хамрагдсан багш нарын ихэнх нь судалгааны зорилтыг зөв тодорхойлжээ.




Зураг 8

Судалгааны арга

Судалгааны арга зөв сонгон хэрэглэсэн 77.9 %, судалгааны арга, сургалтын арга хольсон 29.5 %, судалгаанд хэрэглээгүй аргаа бичсэн 46.7 %, судалгаанд хэрэглэсэн аргаа бичээгүй 15.8 %, аргаа дутуу бичсэн 20.7 % байна.

Зураг 9

Судлах зүйл, судалгааны объект




Судалгааны судлах зүйл нь зорилготой уялдаж чадсан 72.7 %, объектын элемент болж чадсан 77.9 %, судлах зүйлийг зөв томъёолсон 72.9 % -ийг эзэлж байгаа нь судлах зүйлээ зөв томъёолж буйг харуулж байна.

Судалгааны объект нь зорилготой уялдаж чадсан нь 77.9 %, объект нь судлах гэж байгаа


асуудалд чиглэгдэж чадсан нь 57.1 %, объект нь шийдэх асуулыг өөртөө багтааж чадсан нь 62.3 %, объектоо бүтэн системийн хэмжээнд авч чадсан нь 54.5 %, объектоо судалгааны зорилгод тохируулж чадсан 57.1 %, объектыг хэт өргөн хүрээнд авсан нь 31.2 % -ийг эзэлжээ.

Зураг10
Шинэлэг тал




Судалгааны шинэлэг талыг 67.5 % зорилготой зөв уялдуулж бичжээ. Үүнээс 44.2 % шинэлэг талаа нэг асуудлаар тодотгож өгсөн, 25 % шинэлэг талаа хоёр асуудлаар тодотгож өгсөн, 30.7 % шинэлэг талаа гурваас дээш асуудлаар тодотгож өгсөн бол судалгааны шинэлэг талыг бичээгүй нь 32.5 %-ийг эзэлж байна.

Зураг 11
Судалгааны таамаглал



Судалгааны таамаглалыг 48 % нь зорилготой уялдуулж чадсан, 52 % нь эмпирик түвшинд таамаглалыг шалгаж болохоор дэвшүүлжээ.

Зураг 12
Хамрах хүрээ



Судалгааны хамрах хүрээг 98,7 % зөв тодорхойлсон байна. Эндээс үзвэл судалгаанд хамрагдсан Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нар судалгааны хүрээг зөв тодорхойлж чадаж байна.

Онолын ач холбогдол

Судалгаанд хамрагдсан багш нар онолын ач холбогдлыг бичихдээ 48 багш нэг асуудлаар, 19 багш хоёр асуудлаар, 4 багш гурван асуудлаар, 6 багш дөрвөн асуудлаар шинжлэх ухаанд тодорхой хувь нэмэр оруулсан гэжээ.

Практик ач холбогдол

Судалгааны ажлын практик үр дүнг өөрийн үйл ажиллагаанд 33 багш нэг субъект, 35 багш хоёр субъект, 3 багш дөрвөн субъект ашиглаж болно гэж бичсэн бол 6 багш практик ач холбогдлыг огт дурьдаагүй байна.

ДҮГНЭЛТ

1. Багш нар судалгаа хийх чиглэлээ ихэвчлэн бага насны хүүхдийн хөгжлийн асуудалд хандуулжээ. Энэхүү хандлагань сургуулийн өмнөх боловсролын судалгааны ажлын тэргүүлэх чиглэлтэй тохирч байна.
2. Судалгааны дүнгээс харахад сэдэв сонгосон үндэслэлийг зөв гаргаж чадахгүй байна.
3. Судалгааны зорилго, зорилт, судлах зүйл, объектоо ихэнх багш нар оновчтой томъёолсон боловч дотоод логик уялдаа холбоог нарийн гарган томъёолж чадаагүй байна.
4. Судалгаанд хамрагдсан багш нар судалгааны арга, шинэлэг тал, таамаглал, онол, практикийн ач холбогдлоо үйл ажиллагаа, үр дүнд тулгуурлан бичсэн сайн тал ажиглагдлаа.
5. Багш нарт судалгааны ажлын эрдэм зүйн хэрэглэгдэхүүнийг дотоод логик уялдаа холбоотой бичих туршлага, арга зүй дутмаг байгааг судалгааны үр дүн харууллаа. Иймээс цаашид шинэ залуу багш нарт энэ чиглэлээр тусалж дэмжих хэрэгцээ, шаардлага урган гарч байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Авдай, Ч. (2013). Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй. Улаанбаатар
- Батхуяг, С. (2010). Шинжлэх ухааны судалгааны арга. Улаанбаатар
- Ванчинсүрэн, Д. (2001). Судалгаа шинжилгээний арга зүй. Улаанбаатар
- Жадамбаа, Б. (2001). Судалгаа шинжилгээний арга зүй. Улаанбаатар
- Цэрэндорж, Га. (1998). Сурган хүмүүжүүлэх ухаан, бие бялдрын хүмүүжлийн судалгааны ажлын арга зүй (тест)-ийн зарим асуудал. Улаанбаатар